




Шинэ бүтээл дахин төрдөггүй

Есүс Христ энэ дэлхий дээр байхдаа “эцгүүдэд өгсөн амлалтуудыг батлахын тулд... хозлуулагсдын [=еврейчүүдийн] зарц болсон” билээ (Ром 15:8).



Өөрөөр хэлбэл, Есүс шинэ зүйл илчлэх гэж биш, хуучны зүйлсийг батлах гэж ирсэн. Иймд Түүний тухайн үед хэлсэн бүх үг, хэрэглэсэн бүх дүрслэл өмнөх олон зууны турш Израилд илгээгдсэн эш үзүүлэгчдийн үгэн дээр үндэслэсэн бөгөөд Израилд амлагдсан Хаант улстай холбоотой.

Дараа нь үндэстнүүдэд

зарлахаар Паулд захисан Түүний сайн мэдээ нь үүнээс илүү өргөн цар хүрээтэй шинэ илчлэл юм.

Өмнөх нийтлэлд бид Паулын бичсэн шинэ зүйлсийн зарим онцлогийг авч үзээд Хаант улсын тухай сайн мэдээнээс үнэн ялгаатай болохыг нь олж харсан. Тухайлбал: Еврейчүүдэд зориулсан сайн мэдээгээр өгөгдсөн нигүүлсэл хэм хэмжээтэй. Харин үндэстнүүдэд зарласан сайн мэдээ нь ямар ч болзолгүй, хэмжээлшгүй их нигүүлслээр бялхана. Еврейчүүдийн хувьд Христийн Загалмай өөрсдийг нь буруутгах хэрэг бөгөөд бүдрүүлэх саад билээ. Харин үндэстнүүдэд Паул тэр л Загалмайн ачаар



бүтээсэн авралыг тунхаглаад Загалмайгаар бахран бахаддаг. Загалмайн үндсэн дээр үндэстнүүдэд уучлал өршөөл ирээгүй, харин үүнээс хавьгүй агуу сайхан бэлэг болох Зөвтгөл бөгөөд зөвтгөлөөс үүдэн Ертөнцийн Эзэнтэй эвлэрэх Эвлэрэл ирсэн.

Хоёр сайн мэдээний хоорондох ялгаа нь үүгээр дуусаагүй. Бичвэрүүдийг сайтар шинжиж үзэхээр тэс өөр хоёр бүлэг хүмүүст хандуулсан, хоёр янзын агуулгатай хоёр мэдээ нь том жижиг янз бүрийн ялгаатай болохыг олж мэднэ. Бичвэрүүдэд ялгаатай зүйлсийг бид ялгаж сурах нь маш чухал. Есүсийн ярьсан “дахин төрөх”-ийг Паулын бичсэн “шинэ бүтээл”-тэй хольж хутгах нь түгээмэл боловч аварга том ялгаатай утга учрыг нь энэ нийтлэлд авч үзье.

Дахин төрөлт нь Израил үндэстэнд хамаатай

Нэгэн шөнө иудейчүүдийн удирдагч, фарисай Никодем Есүстэй уулзахаар ирж, яриагаа эхлүүлэхдээ, “Рабби, Таныг Бурханаас ирсэн багш гэдгийг бид мэднэ. Яагаад гэвэл Бурхан л хамт байхгүй бол хэн ч Таны үйлддэг шиг тэмдгүүдийг үйлдэж чадахгүй” гэв. Үүнд Есүс шууд л Израилд амласан Хаант улсад орох шаардлагыг ярьж: “Хэн дахин¹ эс төрнө, тэр Бурханы хаанчлалыг үзэж үл чадна” гэжээ (Иохан 3:2-3).

1 Грек үг нь (G509) “дээрээс”, “эхнээс нь”, “дахин” гэсэн утгатай. Никодем үүнийг “хоёр дахь удаа” гэж ойлгосон учраас (Иохан 3:4) бид “дахин” гэсэн олны танил болсон орчуулгыг сонголоо. Энэ нь буддын шашны шинэ төрөлттэй ямар ч холбоогүй сургаал болохыг анхаарна уу!



Никодем энэ үгийг шилжсэн утгаар биш, шууд утгаар нь бодож, хүн буцаад эхийнхээ хэвлийд орж, хоёр дахь



удаагаа хэрхэн төрөх вэ дээ гэж гайхлаа. Есүс хэлэх гэснээ тодруулж, тэр Хаант улсад орохын тулд хүн заавал “ус болон сүнснээс төрөх” ёстой гэв (Иохан 3:5). Энэ үгийг ч Никодем ойлгоогүйд Есүс гайхсан. Фарисай хүний ёсоор Никодем «Хуучин гэрээ»-ний бичвэрүүдийг амьдралынхаа турш судалсан учраас Есүсийн үг Исаиа, Езекиел хоёрын зөгнөлийг заасныг ойлгох л ёстой байв.

Төрөх гэдэг нь байгаа зүйлээс шинэ зүйл гарч ирэхийг хэлнэ. Тэр нь шинэ ч гэсэн адилхан төрлийн зүйл бөгөөд адил “эд материал”-аар бүрдэх билээ. Үүнчлэн Ертөнцийн Эзэн эртний Израилаас гаралтай хүмүүсээс шинэ амьтай шинэ үндэстэн бий болгохоо олон зууны өмнө амласан байв. Тухайлбал:

“Израилын гэрт өгүүл... Би та нарыг үндэстнүүдээс гаргаж, та нарыг хамаг газраас цуглуулж, эх нутагт чинь аваачих болно. Тэгээд



Би та нарын дээр цэвэр ус цацаж, та нар цэвэр болно. Би та нарыг хамаг хир буртгаас чинь, хамаг шүтээнээс чинь цэвэрлэх болно. Тэгээд Би та нарт шинэ зүрхийг өгч, та нарын дотор шинэ сүнсийг өгнө. Би бие махбодоос чинь чулуун зүрхийг зайлуулж, та нарт махан зүрхийг өгнө. Би Сүнсээ та нарын дотор оруулж, та нарыг зарлигуудаараа явуулна. Та нар тогтоолуудийг минь сахин биелүүлнэ. Эцэг өвгөдөд тань Миний өгсөн газарт та нар амьдрах болно. Та нар ард түмэн минь болж, Би Бурхан чинь болно.” (Езекиел 36:22,24-28; АБ)



Энэ зөгнөлийн дагуу бүх үндэстний дунд тархсан Израилын ард түмнийг Ертөнцийн Эзэн эртний эх нутагт нь цуглуулна. Нутагт нь тэднийг усан баптисмаар гэм нүглээс нь цэвэрлэн, улмаар шинэ “махан зүрх”-ийг ч, Өөрийн Сүнсээ ч өгнө.



Анх Синай уулын бэлд Ертөнцийн Эзэнтэй гэрээ хийж, Хуулийг нь Мосегээр дамжин хүлээж авсан цагаас эхлэн израилчууд байнга л дуулгавар муутай, гэрээгээ зөрчин, зөв замаас гажсаар л байсан



бол шинэ зүрх, шинэ сүнс хүлээж авахын үр дүнд Ертөнцийн Эзэний хүслээр явж, Хуулийг нь сахих чадвартай болно. Ертөнцийн Эзэний амласан Хаант улсад орохын тулд израил хүн болж төрөх нь хангалттай гэж Никодем бодсон бол тийм биш ажээ. Заавал “дахин төрөх” буюу сүнсээрээ шинэчлэгдэх ёстой. Дан махбодоос төрсөн хүн бол Ертөнцийн Эзэнээс төрөөгүй юм (1 Иохан 4:7, 5:1,4).²

Энэ дэлхийн байдлыг харахаар Езекиелийн зөгнөл өдий хүртэл биелэгдээгүй байна. 1948 онд Израил улс байгуулагдсныг олон хүн дээрх зөгнөлийн биелэл гэж ойлгодог. Гэвч тэр улсад одоогийн байдлаар дэлхийн иудейчүүдээс тал нь төдий цугларсан бөгөөд тэд нэг бол шашингүй, нэг бол өөрийн зохиосон шашны дүрмийг дагадаг болохоос Ертөнцийн Эзэний Хуулийг дагадаггүй. Иймд дахин төрөх үндэстний тухай зөгнөл биелээгүй нь лавтай.



2 Энэ сүнслэг шинэчлэлтийг мөн Ертөнцийн Эзэний Израилтай тогтоох “шинэ гэрээ” гэж нэрлэдэг (Иеремиа 31:31-33). Энэ шинэ гэрээг Есүс 2000 жилийн тэртээ Өөрийн цусаараа хэдийнэ “тогтоосон” (грек: “хуулиар-тавьсан”, G3549). Тэгсэн ч гэсэн “байгуулагдах” (грек: “хамт-дуусгах”, G4931) нь дутуу (Еврей 8:6,8).



Ямартай ч, “ТА НАР дахин төрөх ёстой” гэсэн нь (Иохан 3:7, олон тоо) хувь хүнд биш, харин бүхэл бүтэн ард түмэнд ба ялангуяа удирдлагад нь хэлсэн үг. Улмаар, Есүс энэ үгийг бусад үндэстэнд хэлээгүй. Энэ үг бусад үндэстний дундаас эх нутагт нь цугларах Израил үндэстэнд л хамаатай (Матай 24:31-г үзнэ үү). Израил “дахин төрөх” дүрслэл Исаиагаас үүдэлтэй. Тухайлбал:

“Ганц мөчид үндэстэн үүсдэг бил үү?
Гэтэл Цион³ дуншмагцаа үр хүүхдүүдээ
төрүүлэв.” (Исаиа 66:8)

Шинэ бүтээл дахин төрдөггүй

Тэгвэл Есүс, Петр, Иаков нар “дахин төрөх” тухай ярьсан, бичсэн боловч (1 Петр 1:4,23; Иаков 1:18), үндэстнүүдэд илгээгдсэн Паул яагаад хэзээ ч “дахин төрөх” тухай бичээгүй нь ойлгомжтой боллоо. Паул харин “Христ дотор” буй итгэгчдийг “цоо шинэ бүтээл” болсныг баталдаг (2 Коринт 5:17). Шинэ бүтээлийг Есүсийн ярьсан “дахин төрөх”-тэй адилтгах нь түгээмэл боловч утга нь тэс өөр.



3 Цион буюу Сион бол Иерусалим хотын бас нэгэн нэр.



Израил үндэстний “дахин төрөх” нь зүйрлэвээс хуучин байшинг засаж, хиртэй бүхнийг нь цэвэрлэн угааж, муудсан хэсгийг нь шинэ хэсгээр сольж шинэчлэхийн адил.

Харин шинэ бүтээл бол цоо шинэ төрлийн байшинг цоо шинэ материалаар барих явдал мэт юм. Шинэ бүтээл байгаа зүйлээс гарч ирдэггүй.

Шинэ бүтээлийн үлгэр загвар нь Адам. Адам эрийн цээнд хүрэхийн тулд арчаагүй нялх хүүхэд болж төрөн өсөөд бага насыг туулах шаарлагагүй байв. Тэрээр Бүтээгч Эзэний мутраас бие бялдар болон ойлгох чадварын хувьд бүрэн төгс гарчээ.



Шинэ бүтээл нь хүүхэд насыг алгасаж, нэгмөсөн эрийн цээнээс эхэлдэг. Үүнээс харахад, шинэ бүтээл нь төгс төгөлдөр байдлыг илэрхийлдэг, харин төрөлт нь шинэчлэлийг дүрсэлнэ.

Хэмжээлшгүй хайр ивээлийн сайн мэдээнд итгэсэн хүмүүс сүнснийхээ хувьд шинэ бүтээл болсон ч, махбод нь шинээр бүтээгдэх нь дутуу байна. Шинэ махбодтой болох тэр өдөр шинэ бүтээл нь гүйцэд болно (Ром 8:19,23). Энэ замаар Ертөнцийн Эзэн



Христийн жишгээр төлөвшсөн олон хөвгүүдтэй болно. “Хөвгүүн” гэдэг нь Бичвэрүүдийн хэллэгээр, эцгийнхээ ажилд хамтардаг том хүүг хэлнэ. “Бурханы Сүнсээр удирдуулж байгаа хүн бүр Бурханы хөвгүүд юм” (Ром 8:14).

Харин израилынхныг нэгмөсөн дахин төрөхөөр Ертөнцийн Эзэн олон хүүхэдтэй болно (Иохан 1:11-12). Тэр хүүхдүүдээ Тэрээр мянган жилийн турш дагуулж, олон зүйл зааж, том хүүгийн төлөвшилтөд авчран шинэ дэлхийн бүтээлд бэлдэх болно.

Пентекост бол дахин төрөлтийн үлгэр загвар

2000 жилийн тэртээ Есүс элч нарынхаа хамт Израилын төрөлтийн бэлтгэл хийжээ. Үүнд Ариун Сүнс бууж ирсэн Пентекост баяр ч их чухал. Тэр баяраар Петр цугласан иудейчүүдэд: “Гэмшигтүн, гэм нүглээ уучлуулахын төлөө та нар цөм Есүс Христийн нэрээр баптисм хүртэцгээ. Ингэснээр та нар Ариун Сүнсийг бэлэг болгон авах болно” гэж зарлажээ (Үйлс 2:38). Энэ бол “ус ба сүнснээс төрөх”-ийн үлгэр загвар юм.⁴



4 Иоханы баптисм Есүс Христийн нэрээр хийгдээгүй, мөн хүмүүст Ариун Сүнсний бэлэг хүртээгээгүй (Иохан 7:39). Тиймээс Иоханы баптисмыг хийсэн, хийгээгүй хүмүүс “цөм” энэ шинэ баптисмыг хүртэх ёстой байв.



Пентекост бол Ертөнцийн Эзэний Израилд тогтоосон ургацны баяр.⁵ Пентекост баяраар израилчууд улаан буудайн шинэ ургацын дээжээр исгэсэн гурилаар талх жигнэн, сүмийн өргөөнд Их Эзэнд анхны үр жимс болгон даллан барьдаг байв. Гурлыг исгэдэг хөрөнгө нь гэм нүглийн бэлэг тэмдэг



бөгөөд эдгээр талх нүгэлт хүмүүсийг билэгшээдэг. Иймд эдгээр талхыг Их Эзэний ширээн дээр өргөж болохгүй, тахилчдад өгдөг байсан. Улмаар, эдгээр талхыг даллахаас өмнө

заавал шатаалт, нүглийн ба эвийн тахилыг өргөдөг байсан (Хууль 23:18-20). Эдгээр тахил бүгд Христийн Загалмай дээрх өргөлийг бэлэгшээдэг. Христийн өргөлийн ачаар л Ертөнцийн Эзэн гэмт хүмүүсийг хүлээж авна.

Яг энэ баяраар Ариун Сүнс бууж ирсний дараа 3000 хүн Есүст итгэж усан баптисм хүртсэн. Иймд Пентекост баяраар өргөдөг талх нь Израил үндэстнээс Их Эзэнд ирсэн дээжийг билэгдэнэ. Энэ утгаар Иаков хожим бичихдээ: “Тэр Өөрийн хүслээр биднийг үнэний үгээр төрүүлэв. Ингэснээр бид Түүний бүтээлүүдийн анхны үр жимс нь болох юм.” (Иаков 1:18). Үүнээс ч харахад Үйлс 2-ын Пентекост баяр дахин төрөхтэй нягт холбоотой.

5 Жилд гурван ургацны баяр байсан (Хууль 23:10-17). Тухайлбал: (1) хаврын Исгээгүй талхны баяр, (2) мөн хавар болдог пентекост баяр, (3) намрын “ургац хураалтын баяр” (буюу Урцны баяр).



Исгээгүй талхны баяр бол амиллын үлгэр загвар

Паул болохоор Христийг “анхны үр жимс” болохыг хэлсэн. Гэхдээ энэ нь дахин төрөлттэй биш, дахин амиллын шинэ бүтээлтэй холбоотой. Христ бол үхэшгүй амьтай болсон анхны хүн. Үүнд:

“Христ үхэгсдээс амилуулагдсан бөгөөд нойрсогсдын анхны үр жимс мөн. Учир нь үхэл нэг хүнээр ирсэн тул үхэгсдийн амилал мөн нэг хүнээр иржээ. Адам дотор бүгд үхдэгчлэн Христ дотор бүгд амьд болгогдоно. Харин тус бүр өөрийн дараалалтай байна. Христ бол анхны үр жимс...” (1 Коринт 15:20).

Пентекост баяраас тавь хоногийн өмнө болдог “Исгээгүй талхны баяр”-аар израилчууд арвайн ургацныхаа дээж юүжийг сүмийн өргөөнд авчирч Их Эзэний өмнө даллан барьдаг байсан. Есүс Дээгүүр өнгөрөх баяраар нас барж, исгээгүй талхны баяраар дахин амилсан учраас өнөө дээж юүж Түүнийг л билэгшээдэг (1 Коринт 15:20).



Ертөнцийн Эзэн өвөг дээдсийг нь Египетийн боолчлолоос гаргаж чөлөөлснийг израилчууд энэ баяраар эргэн санаад “Исгэсэн ямар ч зүйлийг идэж болохгүй” байв (Египетээс гарсан нь 13:3). Учир нь Их Эзэний хийдэг зүйлд ямар ч гэм нүгэл оршихгүй.



Есүс Христ үхэгсдийн дундаас амилахдаа Загалмай дээр тээж байсан дэлхийн хамаг гэм нүглийг булшинд үлдээжээ. Тэр Өөрөө цоо шинэ бүтээл болж өнөө булшнаас гарсан. Түүний хийсэн ажил төгс бөгөөд Адамын учруулсан асуудлыг эргүүлж, хүн төрөлхтөнийг үхлийн боолчлолоос чөлөөлөхөд хүргэх болно (1 Коринт 15:20-28).

Дахин төрөх нь өвдөлтөөр эхлэх ёстой

Төрөхөөс өмнө төрөхийн өвдөлт явагдах нь жам. Шилжсэн утгаар хэлэхэд, Израил үндэстэн дахин төрж, Хаант улсад орохоос өмнө хэцүү үеийг даван туулах ёстой. Энэ тухай Есүс мөн зөгнөжээ. Хаант улсаа хэзээ байгуулах талаар дагалдагч нар



нь нэгэн өдөр асуухад Есүс энэ үеийн төгсгөлийн тухай тайлбарлан, Түүний нэрээр хүмүүсийг мэхлэгчид гарч ирэн, дайн дажин, өлсгөлөн, газар хөдлөлт зэрэг хөнөөлтэй зүйл

тохиолдоно гэсэн. Гэхдээ “энэ бүгд нь төрөх өвдөлтийн зөвхөн эхлэл юм” гэжээ (Матай 24:3-8). Үүний дараа хүмүүс Христийг дагадаг иудейчүүдийг “зовлон гамшигт тушаах” бөгөөд өмнө нь хэзээ ч тохиолдоогүй “их гамшиг” болно гэсэн (Матай 24:9-21). “Гамшиг” гэж орчуулсан грек үг (G2347) дарамт шахалт, зовлон зүдгүүрийг хэлнэ.



Их гамшгийн тухай Есүсийн үг бас л эртний зөгнөлд үндэслэсэн. Иеремиа “Иаковын⁶ зовлон шаналангийн үе”-ийн тухай зөгнөхдөө энэхүү үеийг мөн төрөхтэй зүйрлэсэн, улмаар израилчууд тэр үлэмж хэцүү үеэс аврагдана гэсэн (Иеремиа 30:6-7, АБ).

Есүс үргэлжлүүлэхдээ, “гамшгийн тэр өдрүүдийн дараа” Өөрөө тэнгэрийн үүлэн дээр эргэж ирээд ер бусын элч нараараа сонгосон хүмүүсээ даян дэлхийгээс цуглуулах болно гэж амласан (Матай 24:29-31, дээр иш татсан Езекиелийн зөгнөлийг үзнэ үү!).

Тэгээд Есүс Их Эзэн энэ дэлхий дээр мянган жил үргэлжлэх Хаант улсаа байгуулна. Хаант улсаа байгуулахаа, удаан хүлээлгэсэн сүйт залуу нь эцэст нь ирж, сүйт бүсгүйгээ гэртээ авчирж хуримаа хийж баярлан хөөрөхтэй зүйрлэсэн байна (Матай 25:1-13). “Дахин төрөх” нь “өвдөлт”-ийнх нь хамт Израил үндэстнийг тэр мянган жилийн турш ба үүнээс хойш ариун зөв амьдрах чадвартай болгоно.

Хуучин бүтээл Загалмай дээр устгагдсан нь

Шинэ бүтээлд төрөх өвдөлт мэдээж байхгүй. Гэтэл хуучин бүтээл шинэ бүтээлд зай тавихын тулд устгагдах ёстой. “Хуучин хүн [төрөлхтөн] маань Түүнтэй хамт цовдлогдсоныг бид мэддэг” гэсэн нь

6 Иаков бол Абрахамын ач байв. Иаковын нэрийг Ертөнцийн Эзэн “Израил” болгон өөрчилсөн билээ (Эхлэл 32:28). Иаковын 12 хүү нар Израилын 12 овгийн эцэг болжээ. Иймд “Иаков” гэсэн нэр мөн хамаг Израилыг төлөөлж болдог.



тийм учиртай (Ром 6:6).
Өөрийгөө Христ дотор
учраас Түүнтэй хамт
цовдлогдон дахин амилснаа
мэдэн итгэсэн үедээ хүн
шинэ бүтээл болдог.



Тэгвэл бид өнөөдөр ч “ялзарч
буй хуучин хүнээ тайлж, оюун
санааныхаа сүнс дотор шинэчлэгдэж, жинхэнэ зөвт
байдал ба ариун чанар дотор Бурханы дагуу
бүтээгдсэн шинэ хүнийг өмс”-өх нь зохистой (Эфэс
4:22-24). Тэрхүү шинэ хүн төрөлхтөн “бол өөрийг нь
бүтээсэн Түүний дүр төрхийн дагуу үнэн мэдлэгт
шинэчлэгддэг хүн юм” (Колоссай 3:8-10).

Хуучин хүнээ цамц шиг “тайлж, шинэ хүнийг өмсөх”
нь одоогийн байдлаар сүнсний хувьд, бодол дотор
явагддаг. Христийн тухай үнэн мэдлэгийг хүлээн авч,
Түүнийг одоо ч шинэ бүтээлд амьдарч байгаа тухай
тунгаан бодсноор бид өөрсдөө ч шинэ бүтээл
болсон ивээлээ улам сайн ухааран авснаар шинэ
хүнийг “өмсдөг”. Их Эзэн биднийг зөвд тооцон, ариун
гэж хардаг гэснийг нь өөртөө “өмсөх”-өөр, биеэ авч
явах байдал маань ч өөрчлөгдөнө (Эфэс 4:25-32).


Их Эзэн маань эргэж ирэхдээ “дорд биеийг маань
Өөрийнхөө цог жавхланта биетэй адил болгон
өөрчилнө” (Филиппой 3:21). Тэр үед шинэ хүн маань
бүрэн дүүрэн болно.



Жич: Библид Паулаас өөр хэн ч “хуучин хүн”, “шинэ хүн”-ий тухай бичээгүй. Зөвхөн Паул Адамын учруулсан асуудлын тайллыг танилцуулдаг. Үүнд: цоо шинэ бүтээл.

Ирээдүйн хоёр зон үе

Ертөнцийн Эзэний төлөвлөгөөг илүү сайн ойлгохын тулд Түүний хуанлийн гол хэдэн хүснэгтийг мэдэх хэрэгтэй. Бид “одоогийн зон” үеийн төгсгөлд байна (x).



“Мөнх” гэсэн үгийн тухай судалгааг маань та уншсан бол Бичвэрүүдэд “мөнхийн” буюу “зон үе” олон тоогоор ч гардагийг мэднэ. Ертөнцийн Эзэний хуанлид ирээдүйн хоёр тийм үе товлогдсон байдаг.

Эхнийх нь Израил үндэстэнд амласан Хаант улсынх бөгөөд одоогийн үеийн төгсгөлөөс эхэлж, шинэчилсэн энэ хөрст дэлхий дахиныг хамран, мянган жилийн турш үргэлжлэх болно (Даниел 7:27; Илчлэл 20:4).



Мянган жилийн үе төгсөхөд “газар, тэнгэр зугтсан бөгөөд тэдэнд байх газар эс олдов” гэж Иохан үзэгдлээр харж бичив (Илчлэл 20:11). “Тэнгэр, газар өнгөрөн одно, харин Миний үгс өнгөрөн одохгүй” гэж Есүс хэлэхдээ энэ хөрст дэлхийн тэр төгсгөлийг ярьсан (Матай 24:34). Тэгээд Ертөнцийн Эзэн шинэ тэнгэр, шинэ газрыг бүтээхээр дараагийн эон үе эхлэх болно (Илчлэл 21:1).

Үүнээс харахад израилчуудын Хаант улс хуучин хөрст дэлхийд явагдана. Израилчууд дахин төрсөн ч хуучин хүн төрөлхтөнд хамрагдсан хэвээр. Иймд тэд Ертөнцийн Эзэнд хүлээн зөвшөөрөгдөхийн тулд гэмшиж, усан баталгаа хүртэж, итгэлтэйгээ батлан сайн үйлс гаргах зэрэг янз бүрийн юм хийх хэрэгтэй.

Харин Паулын зарласан сайн мэдээнд итгэсэн хүмүүс сүнсээр Хаант улсын шинэчлэлийг алгасаад, одоо ч шинэ тэнгэр, шинэ газрын бодит бүтээлд дүйцнэ. Христ дотор шинэ бүтээл болсон хүмүүс нь сүнсээрээ Адамын тэргүүлсэн хуучин хүн төрөлхтөнд хамрагдахаа больж, шинэ хүн төрөлхтөнд хамрагдана. Энэ үнэнг бид махбодоосоо хараахан харахгүй ч гэсэн Паул биднийг энэ тал дээр “үзэгдэх зүйлээр бус, харин итгэлээр алхдаг” байхад уриалдаг (2 Коринт 5:7).





Дүгнэж хэлэхэд, дахин төрөлт ба шинэ бүтээл хоёр тэс өөр ойлголт. Дахин төрөх нь «Хуучин гэрээ»-нд амлагдсан, Израил үндэстэнд хамаатай. Пентекост баяраар билэгдсэн энэ ирээдүйн үйл явдлын өмнө төрөх өвдөлт ч байх учиртай. Төрөх явдлаар хуучин зүйлээс шинэ юм гарсан ч, хуучин “эд материал”-аар бүрдэнэ. Иймд Израил үндэстэн дахин төрөхөөр Есүс Христ тэдэнд амлагдсан Хаант улсыг энэ л шинэчлэгдсэн хөрст дэлхий дээр байгуулж, энэ л хүн төрөлхтөнийг хаанчлах болно.

Харин Паулын зарласан сайн мэдээний дагуу Христ, Исгээгүй талхны баяраар бэлэгдсэнчлэн, үхэгсдийн дундаас амилахдаа хуучин хүн төрөлхтөнг үгүй болгож, шинэ бүтээлийг эхлүүлсэн. Түүний дотор буй итгэгч болгон Түүнтэй хамт цовлогдсонд тооцогддог учраас одоо ч сүнсээр Түүн шиг шинэ бүтээл болсон. Дахин төрөлтөөр хүүхэд төрдөг бол бүтээлийн үйл явдлаар эхнээс нь эрийн цээнд хүрсэн шинэ хүн бий болдог. Шинэ бүтээл хуучин зүйлээс огт ангид учраас Паулд өгөгдсөн илчлэлт Хаант улсын үед зориулсан үнэнийг алгасан дараагийн үетэй дүйцнэ.





Ингээд Хэмжээлшгүй их хайр ивээлийн сайн мэдээ нь үлэмж өргөн хүрээтэй, хэт холын алсын хараатай учраас “харснаараа биш, итгэлээрээ” гэдэг уриатай байхаас өөр аргагүй юм.

Тэгэж алхаж явах нь мэдээж нэг талын амаргүй ч гэсэн итгэлийг нь Их Эзэн Өөрөө хайрлана (Эфэс 2:8; Ром 12:3).

Түүндээ хамаг зүрх сэтгэлээр талархъя! □

Бүтээх ба төрөхийн аль аль нь махбодтой холбоотой. Гэтэл хоёр сайн мэдээний махбодод хандах хандлага тэс өөр. Нэг нь махбодийг чухалчилдаг, нөгөө нь “махбодод түшиглэдэггүй”. Энэ сонирхолтой сэдвийг бид дараагийн нийтлэлд авч үзнэ.

Ашигласан эх сурвалж

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Шинэ гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.

---Библи (2015). Улаанбаатар : Монголын Библийн Нийгэмлэг. Энэ судалгаанд ББ гэж товчилсон.

---Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Хуучин гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.

---Strong, J. (1890). Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons). www.blueletterbible.org